

**ДИПЛОМАТ, АЛБАН ПАСПОРТ ЭЗЭМШИГЧДИЙГ ВИЗЭЭС ХАРИЛЦАН
ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ БРАЗИЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын Засгийн газар (цаашид “Хэлэлцэн тохирогч Талууд” гэнэ),

Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын (цаашид “Хэлэлцэн тохирогч Улсууд” гэнэ) ард түмэн болон Засгийн газрын хоорондын найрамдалт харилцааг бэхжүүлэхийг эрмэлзэн,

Дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч нэг Улсын хүчин төгөлдөр дипломат буюу албан паспорт эзэмшигч иргэд нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын нутаг дэвсгэрт визгүй зорчиж болох бөгөөд орсноосоо хойш ер /90/ хоног хүртэл хугацаанд байх хэрэгтэй.

2 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч нэг Улсаас Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад суугаа дипломат болон консулын төлөөлөгчийн газрын гишүүнээр томилогдсон албан тушаалтан хүлээн авагч Хэлэлцэн тохирогч Улсын нутаг дэвсгэрт албан томилолтынхоо хугацаанд визгүй зорчиж, байж, гарч болно, гэхдээ орсноос хойш гуч /30/ хоногийн дотор хүлээн авагч Хэлэлцэн тохирогч Улсын Гадаад хэргийн яамнаас холбогдох зөвшөөрлийг авах ёстой.

2. Энэ зүйлийн 1-д заасан журам нь тухайн албан тушаалтны гэр бүлийн хүмүүст мөн хамаарна.

3 дугаар зүйл

1. Энэхүү Хэлэлцээрт дурдсан паспорт эзэмшигчид нь Хэлэлцэн тохирогч Улсуудын хилийн олон улсын зорчигчдод нээлттэй боомтоор зорчино.

2. Энэхүү Хэлэлцээрт заасны дагуу визээс чөлөөлөх нь гадаадын иргэд орох, байх, гарахтай холбогдсон Хэлэлцэн тохирогч Улсуудын хүчин төгөлдөр хууль тогтоомжийг сахиж мөрдөх үүргээс тухайн паспорт эзэмшигчийг чөлөөлөхгүй.

4 дүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд тухайн этгээдийг оруулах буюу байлгах нь тааламжгүй гэж үзвэл нутаг дэвсгэртээ оруулах буюу байлгах зөвшөөрөл олгохоос татгалзах эрхээ хадгалж үлдээв.

5 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Тал бүр нийтийн дэг журам сахиулах, аюулгүй байдлаа хангах, эсхүл нийтийн эрүүл мэндийг хамгаалах шалтгаанаар энэхүү Хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоож болно. Ийнхүү түр зогсоосон болон зогсоосноо цуцалсан тухайгаа нөгөө Хэлэлцэн тохирогч Талд дипломат шугамаар даруй мэдэгдэнэ.

6 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос гуч /30/ хоногийн өмнө дипломат болон албан паспортын загварыг шинж тэмдэг, хэрэглэх зааврын хамт дипломат шугамаар солилцоно.

2. Хэлэлцэн тохирогч Талууд тухайн паспорт болон түүнийг хэрэглэх заавар өөрчлөгдсөн тухай бүрт харилцан мэдээлж, шинэ паспортын загварыг хэрэглэхээс гуч /30/ хоногийн өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө Талд өгнө.

7 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээр түүнд гарын үсэг зурснаас хойш жар /60/ хоногийн дараа хүчин төгөлдөр болох бөгөөд хугацаагүй үйлчилнэ. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа гуч /30/ хоногийн өмнө дипломат шугамаар бичгээр мэдэгдэж түүнийг хүчингүй болгож болно.

2007 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Бразилия хотноо монгол, португаль, англи хэлээр үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Орчуулгын зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг

**ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ
БРАЗИЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг